

Захирлын зөвлөлийн ...оны
...сарын.....өдрийн хурлаар
хэлэлцэн батлав.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

1. Тэтгэлэгийн зорилго

Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудын сургалт, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлж, нийгмийн идэвхийг өрнүүлэх, тэдний бие дааж ажиллах, мэдлэг чадварыг өндөржүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

2. Тэтгэлэгийн хэмжээ, хугацаа

- a) Шалгарсан оюутанд олгох тэтгэлэгийг жилдээ нэг удаа олгоно. Тэтгэлэгийн хэмжээ сургалтын төлбөрийн 10 хувьтай тэнцүү байна. Тэтгэлэгийн хэмжээг жил бүр үнийн өсөлттэй уялдуулан шинэчилнэ.
- b) Тэтгэлэг олгох тухай Захирлын тушаал гарсны дараа тэтгэлэг авах оюутанд тусгай батламж олгоно.
- c) Тэтгэлэгийг гуравдугаар курсын эхний улирлаас эхлэн олгож, хэрэв сурлагын чанар буураагүй бол сургуулиа төгстөл нь олгоно.
- d) Тэтгэлэгийг сургалтын төлбөрт шилжүүлэх, эсвэл урамшуулал хэлбэрээр бэлнээр авахаа оюутан өөрөө шийдвэрлэж болно.
- e) Тэтгэлэгийг болзол шалгуур хангасан оюутнуудад олгоно. (Тэтгэлэг авах оюутны тоо тэтгэлэгт хамрагдах болзол шаардлагыг хангасан байдлаас хамаарна.)

3. Тэтгэлэг олгох оюутныг тодорхойлох тухай

- a) Тэтгэлэг олгох оюутны нэрийг сургуулийн үндсэн багш нар, ангийн хамт олон, ХНХДС-ийн дэргэдэх оюутны зөвлөлийн тус тусын саналыг хураан 80-аас дээш хувийн санал нэгдсэн нөхцөлд сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэр гаргана.
- b) Санал хуваагдсан нөхцөлд нууц санал хурааж болно.
- c) Тэтгэлэг зөвхөн өдрийн ангийн оюутнуудад хамааралтай байна.

4. Тэтгэлэг олгуулахаар тодорхойлох оюутныг шалгаруулах гол үзүүлэлтүүд

- a) Дөрвөн улирлын турш өгсөн бүх шалгалтуудын голүнэлгээ 3.7-с дээш байх
- b) Судалгааны чанартай ажилд биечлэн оролцсон (эрдэм шинжилгээний хурал, семинарт илтгэл тавьсан, зарим өгүүлэл, санал, судлагааны үр дүнг хэвлүүлсэн гэх мэт), үүнд дуг сонирхолтой байх
- c) Олон нийтийн ажилд идэвхитэй оролцдог, оюутнуудын дунд нэр хүндтэй, хүмүүжилтэй, харилцааны соёлтой байх

5. Тэтгэлэг олгох өдөр

Тэтгэлэгийг хичээлийн шинэ жилийн нээлтэнд, эсвэл шинэ жилийн баяраар олгож байхаар зохицуулалт хийж болно.